

ТОТАЛИТАРИЗМЫН СУДАЛГААНД ЭРДЭМТДЭЭС БАРИМТАЛСАН АРГА ЗҮЙН ХАНДЛАГУУДЫН ТУХАЙД

Ж.Жаргал багш, докторант

МУБИС, Улс төр социологийн тэнхим

Түлхүүр үг: Тоталитаризм, онол, арга зүй, хандлага, улс төр судлал, үндсэн хуулийн эрх зүй, улс төрийн системийн онол, модернизацийн онол, нийгмийн ба улс төрийн сэтгэл судлал, нийгэм-соёлын ба улс төрийн антропологи

Эрдэмтэд тоталитаризмын онол, түүх, практикийн олон талтай асуудлыг шинжлэн судлахдаа түүний ерөнхий чиг баримжаа болгож онол, арга зүйн янз бүрийн хандлагыг баримталжээ. Тэдгээрт нийтлэг, ижил хийгээд ялгаатай, өөр өөрийн онцлогтой талын аль нь ч байна.

Тоталитаризмын асуудлыг судалсан эрдэмтэд ч, тэдний туурвисан зохиол бүтээл ч олон байгаа учраас тэдгээрийн онол, арга зүйн баримтлалыг нэг бүрчилж бүгдийг нь авч үзэж илэрхийлэн гаргах боломжгүй, бас тэгж судлахыг оролдох нь өөрөө шинжлэх ухаанч арга биш болно. Тиймээс эрдэмтэдээс баримталсан онол, арга зүйн тэдгээр хандлагуудыг тоталитаризмын судалгааны хэд хэдэн зангилаа асуудлын дагуу бүлэглэн хурааж тоймлон авч үзэх зорилт тавьж байна.

Тэдгээр зангилаа асуудал бол тоталитаризмын онтологи буюу оршин ахуй, гарал үүсэлтэй нь холбоотой тоталитаризм гэж юу вэ, ямар гарал үүсэлтэй вэ, ямар зохион байгуулалт, бүтэцтэй вэ, хэрхэн яаж оршин тогтдог вэ гэсэн нэг бүлэг асуулт, түүнийг танин мэдэхтэй холбоотой тоталитаризмыг хэрхэн үзэж ойлгох вэ, яаж судлаж танин мэдэх вэ гэсэн өөр нэг бүлэг асуулт, түүнийг шинжлэх үйл ажиллагаа, арга барилыг хэрхэн яаж зохион байгуулах вэ, тэр нь яавал зөв зүйтэй болж үнэн мэдлэг, хүссэн үр дүнд хүргэх вэ гэдэгтэй холбоотой судалгааны арга зүйн хүрээний бас нэг асуултаас бүрэлдэж байна гэж урьдчилан баримжаалж болох юм. Үүний дээр эрдэмтэдийн баримталсан онол, арга зүйн хандлагуудыг тоталитаризмын судалгааны үндсэн үе шатуудын дагуу, өөрөөр хэлбэл хронологийн аргаар өөрчлөлт, хөгжлийн нь ерөнхий чиг шугам, логик өрнөлийг илэрүүлэн гаргахыг оролдож авч үзэх нь асуудлын судалгааг зохих хэмжээгээр эмх цэгцтэй болгоход тус дөхөм болно гэж үзэж байна.

Тоталитаризмын судалгааны онол, арга зүй, түүнийг баримтлаж хэрэглэсэн үйл явц бүхий “технологи” хийгээд тэдгээрийн үр дүн болж

боловсрон гарсан тоталитаризмын тухай мэдлэг, ойлголт, үзэл санаа, дүгнэлт нь нэг талаар хоорондоо органик нэгдэлтэй, нөгөөтэйгүүр тодорхой хэмжээний ялгаатай. Тэдгээр нь нэгдэлтэй болохын учир бол аль аль нь судалгаа, танин мэдэхүйн нэгдмэл нэгэн үйл явц, чиг шугамын хүрээнд багтаж орно, нэг нь нөгөөгөө бий болгоно. Тэдгээрийн ялгааны учир бол судалгааны үйл явц, түүнд ямар нэг онол, арга зүйг баримтлан хэрэглэх нь оюуны үйлдвэрлэл бөгөөд түүний үр дүн болж гарах мэдлэг, ойлголт, нэгтгэн дүгнэсэн үзэл санаа нь оюуны бүтээгдэхүүн юм.

Эхлээд тоталитаризмын судалгаанд эрдэмтэдээс баримтласан онолын үндэслэлүүдийн талаар дурдъя. Тоталитаризмын судалгааны эхний үед буюу 1920-иод онд түүний онол боловсрон гараагүй, тусгайлсан судалгаа ч зохих ёсоор хийгдээгүй, тоталитаризмыг голцуу улс төрийн нам, хөдөлгөөний зүтгэлтэн, нийтлэлчид өрнөдийн уламжлалт иргэншил, либерализм, ардчилал, эрх, эрх чөлөөний үнэт зүйлсийн үүднээс, улс төрийн байр сууринаас үзэн ойлгох, шүүмжлэн буруушаах явдал давамгайлж байсан учираас тэднийг ямар нэг онол, арга зүй баримталсан гэж үзэх үндэслэл тун хомс юм.

1930-аад онд Итали, Герман, ЗХУ-д тоталитар дэглэм өөр өөр хэлбэр, хэв маягаар тогтож, шинж чанар, зохион байгуулалт, үйл ажиллагаа нь ил тодорхой болж танигдан дэлхий нийтийн, ялангуяа эрдэмтэдийн анхаарлыг ихэд татах болсноор түүнийг тусгайлан судлаж шинжлэх, зохиол бүтээл нийтлүүлэх болжээ. Энэ явцад тоталитаризмын тухай онолын төсөөлөл, ойлголт бүрэлдэх болсон хийгээд асуудалд хэрхэн хандах, ямар арга замаар яаж судлах вэ гэсэн арга зүйн чанартай асуулт тавигдаж тэр дагуу эрэл хайгуул хийгдэж эхэлсэн байна. Гэвч 1940-өөд оны дунд хүртэл буюу тоталитаризмын асуудлаар анхны томоохон суурь бүтээлүүд болох Ф.А.Хаекын “Боолчлогдох зам” 1944 онд, К.Попперын “Нээлттэй нийгэм, түүний дайснууд” 1945 онд хэвлэгдэж гарах хүртэл тоталитаризмын судалгааны онол, арга зүйн үндэс суурь зохих ёсоор тавигдаагүй ажээ. Тийм ч учираас Ф.Хаек, К.Поппер нар дурдсан бүтээлдээ тоталитаризм бодит байдал, ноцтой аюул болж тогтчихоод байхад түүнийг нийгмийн ухаан зохих ёсоор шинжлэн судлах, ухаж ойлгох чадваргүй байгааг шүүмжилж цохон зааж байсан билээ. Энэ нь тэр үед нийтлэгдсэн анхны бие даасан зохиол бүтээлүүдийн үзэл санаа, агуулга, бичлэгээс тодорхой хэмжээгээр харагддаг байна. Тухайлбал 1939 онд нийтлэгдсэн Ф.Боркенаугийн “Тоталитар дайсан” зохиолоос бодож боловсруулан хэрэглэсэн цэгцтэй онол, арга зүйн баримтлал олж тогтооход тун бэрхшээлтэй. Зохиолд тоталитаризмыг дэлхийн хоёрдугаар дайнтай холбож, Европын соёл, иргэншил, эрх чөлөө, ардчилал, хувь хүний эрх, хараат бус байдал, индивидуализмын үүднээс, улс төрийн утга агуулгаар авч үзсэн, нацизм ба большевизмыг ерөнхий байдлаар харьцуулсан зэрэг байдал харагддаг¹⁶.

Гэхдээ 1930-аад онд тоталитар дэглэмүүдийг хооронд нь харьцуулан авч үзэх замаар тэдгээрийн нийтлэг шинж, мөн чанарын нэгдэл болон ялгаа, онцлогыг нь гаргах, үүний тулд юуны өмнө тоталитаризм тогтсон орнуудын улс

¹⁶ Ф.Боркенау. Тоталитарный враг. -Тоталитаризм: что это такое? (Исследования зарубежных политологов) Сборник статей, обзоров, рефератов, переводов. М., 1993. с. 5-16

төр, нийгэм-эдийн засаг, оюун санааны амьдралыг тус бүрт нь сайтар судлах хэрэгтэй гэсэн арга зүйн баримтлал товойж эхэлсэнийг хэлэх хэрэгтэй. Энэ нь Ф.Боркенаугийн зохиолд ч тодорхой хэмжээгээр тусгалаа олжээ.

Тоталитаризмын онол Х.Арендт, Ж.Талмон, К.Фридрих, З.Бжезински, К.Брахер, Р.Арон зэрэг эрдэмтдийн хийсэн судалгаа, нийтлүүлсэн зохиолуудын үр дүнд 1950-иад онд цэгцрэн боловсрогдож томъёологдсон билээ. Цаашдаа түүнийг эрдэмтэд өөрсдийн судалгаандаа тодорхой байдлаар баримтлан хэрэглэх болсон байна. Өөрөөр хэлбэл тоталитаризмын онол нь эл асуудлаар 1940-өөд оноос өдгөө хүртэл хийгдэж ирсэн судалгаа шинжилгээний ажлын онолын ерөнхий үндэс суурь болж иржээ. Тэгэхдээ энэ хугацаанд уг онолыг гадна дотноос нь цөөнгүй удаа шүүмжилж, няцаахыг оролдож байсан боловч тоталитаризм судлагч эрдэмтдийн дийлэнх олонхи нь түүнийг судалгаандаа ерөнхий чиг баримжаа болгож байв. Түүнийг хурцаар шүүмжлэгчид, няцаахыг оролдогчид хүртэл эцсийн дүндээ түүний ерөнхий хүрээнээс халин гарч чадаагүй, тоталитаризмыг судлах өөр шинэ онол боловсрон гараагүй байгаа билээ. Энэ талаар оросын эрдэмтэн Ю.И.Игрицкий, “Тоталитаризмын үзэл баримтлал хэдийгээр төгс төгөлдөр биш, харьцангуй чанартай боловч тоталитар дэглэмүүдийг ул үндэстэй, сайтар судлан тодорхойлоход нэн тохиромжтой өөр онолыг улс төрийн шинжлэх ухаан боловсруулан гаргаагүй л байна” гэж бичжээ¹⁷.

Гэвч үүгээр асуудлыг бүрэн төлөөлүүлж хараахан болохгүй, түүнд тодорхой хандаж зарим зүйлийг тодруулан авч үзэх шаардлагатай болно. Тоталитаризм олон талтай, нарийн нийлмэл үзэгдэл учираас түүнийг тоталитаризмын онолын зэрэгцээ эрх зүй, түүний дотор үндсэн хуулийн эрх зүйн онол, улс төрийн системийн онол, модернизацийн онол, сэтгэл судлал, ялангуяа нийгмийн ба улс төрийн сэтгэл судлал, нийгэм-соёлын болон улс төрийн антропологийн онолоор судлах оролдлого 1960-аад оноос хойш бага ч гэсэн хийгдсэн байна. Тухайлбал Р.Арон “Ардчилал ба тоталитаризм” (1965) гэсэн бүтээлдээ тоталитар дэглэм, түүний дотор өөрийн нь цохон зааснаар ЗХУ-д 1934-1938, 1949-1952 онд хамгийн бүрэн, тод байдлаар тогтон ноёрхож байсан¹⁸ тоталитар дэглэмийн асуудлыг голчлон үндсэн хуулийн эрх зүйн үүднээс авч үзээд үндсэн хуульт дэглэм бол хуулийн мяндсан утсан дээр тогтдог бөгөөд хэрэв тэр нь тасравал сэлэмний ир дээр тогтсон, үндсэн хуульт хийгээд олон ургальч ёсны эсрэг чиглэсэн дарангуй, тоталитар дэглэм тогтох болно гэжээ¹⁹.

Оросын эрдэмтэн А.Н.Медушевский “Демократия и авторитаризм: Российский конституционализм в сравнительной перспективе” (1997) гэсэн том хэмжээний бүтээлдээ ардчилсан бус, дарангуй дэглэмүүд, түүний дотор тоталитаризм, тэр нь ЗХУ-д тогтсон асуудлыг Р.Ароныхтай төсөөтэй онол, арга

¹⁷ Ю.И. Игрицкий. Концепция тоталитаризма: уроки многолетних дискуссий на Западе.- История СССР (Научный журнал АН СССР).1990.№6, с. 172-190.

¹⁸ Р. Арон. Демократия и тоталитаризм. Перевод с французского П.И.Семенова. М., Текст, 1993. с. 229

¹⁹ Мөн зохиол. с. 188

зүйгээр оросын үндсэн хуульт ёсны үүсэл, төлөвшлийн ерөнхий чиг шугаман дээр тавьж авч үзсэн байна²⁰.

Тоталитар дэглэмийг улс төрийн системийн онолоор авч үзсэн бүтээлийн тод жишээ бол Америкийн эрдэмтэн Чарльз Ф.Эндрейны “Comparative political systems. Polity Performance and Social change” (1994) гэсэн зохиол гэж үзэж болно. Түүнийг Орос Улсын Улс төрийн шинжлэх ухааны холбооноос эрхлэн 2000 онд орос хэлээр (“Сравнительный анализ политических систем. Перевод с английского. М., ИНФРА-М, Весь мир, 2000”) нийтлүүлсэн байна. Чарльз Ф.Эндрейн зохиолдоо тоталитар дэглэмийг ерөнхийд нь дайчлагч ба элитийн дайчлагч систем гэсэн хоёр хэв маягт ангилж авч үзжээ²¹. Түүний үзлээр элитийн дайчлагч систем нь Итали, Германд тогтсон тоталитар дэглэмтэй, популист дайчлагч систем нь Зөвлөлт Орос Улсад 1917 онд тогтож байсан дэглэмтэй тус тус тохирох бөгөөд Сталины үеийн ЗХУ-д элитийн дайчлагч систем тогтсон, мөн тэр загвар нь 1948-1992 онд БНАСУ-д Ким Ир Сений үед тогтсон ажээ²².

Итали, Герман, ЗХУ-д тоталитар дэглэм тогтсон явдал бол эдгээр оронд дэлхийн I, II дайны завсрын үед нийгмийг модернизаци хийж эрс өөрчлөн шинэчлэх зорилтыг тухайн үеийн түүхийн нарийн ээдрээтэй, хурцдмал нөхцөл байдлын эрхээр богино хугацаанд нийгмийг хүчлэн дайчлах арга замаар хэрэгжүүлсний туйлын сөрөг үр дагавар байсан гэсэн үзэл буюу тоталитаризмыг модернизацийн үзэл баримтлалаар тайлбарлах оролдлого зарим ном зохиол, өгүүлэл сэлтэд туссан байна²³.

Тоталитаризмын үзэгдэл, түүний дотор эл дэглэмийн дарангуй толгойлогчид болон нийгмийн бааз болох массын нийгэм-сэтгэл зүй, зан байдалын онцлогыг сэтгэл судлал, ялангуяа нийгмийн болон улс төрийн сэтгэл судлал, сэтгэцийн эмгэг судлал, улс төрийн антропологийн онол, үзэл баримтлалын үүднээс судалсан ном зохиол нэлээд байна. Тэдгээрээс Э.Фромм, Теодор Адорно, Д.В.Ольшанский, В.В.Ильин, А.С.Панарин, Д.В.Бадовский, Ф.И.Минюшев зэрэг эрдэмтэдийн бүтээлийг дурдаж болно²⁴. Зарим эрдэмтэдээс тоталитаризмын судалгаанд баримталсан дээрхи нийгэм-

²⁰ А.Н.Медушевский. Демократия и авторитаризм: Российский конституционализм в сравнительной перспективе. М., РОССПЭН, 1997, с. 155-157, 492-556

²¹ Чарльз Ф.Эндрейн. Сравнительный анализ политических систем. Перевод с английского. М., ИНФРА – М., Весь мир, 2000, с. 107

²² Мөн зохиол. с. 110-132

²³ Тухайлбал: Тоталитаризм в Европе XX века. Из истории идеологий, движений, режимов и их преодоления. М., Памятники исторической мысли, 1996. с. 503, 506; Ю.И. Игрицкий. Концепция тоталитаризма: уроки многолетних дискуссий на Западе.- История СССР (Научный журнал АН СССР).1990.№6, с. 172-190; Ю.И. Игрицкий. Меняющаяся Россия как предмет концептуального анализа. – Отечественная история. 1998. 11, с. 3-23; Өрнөдийн эрдэмтэдийн бүтээлүүдээс: В. Jr. Moore. Social origins of dictatorship and democracy in the modern world. Boston, 1966; В.Brugger, К.Hannan. Modernization and revolution. L.,1983.

²⁴ Э. Фромм. Анатомия человеческой деструктивности. Перевод Э.М.Телятникова. М., АСТ-ЛТД, 1998; Теодор Адорно. Исследование авторитарной личности. Перевод с английского. М., Серебряные нити, 2001; Д.В.Ольшанский. Основы политической психологии.-Екатеринбург, Деловая книга, 2001; В.В.Ильин, А.С.Панарин, Д.В.Бадовский. Политическая антропология. Под ред. В.В.Ильина. М., Издательство МГУ, 1995; Ф.И.Минюшев. Социальная антропология. Учебное пособие для вузов. М.,Фонд “Мир”, Академический Проект, 2004.

хүмүүнлэгийн ухааны онол нь тоталитаризмын онолоор хандаж судлахдаа бүрхэг үлддэг, эсвэл түүний аспектэд тэр бүр өртөдөггүй тодорхой асуултуудыг шинжлэхэд багагүй ач холбогдолтой ажээ. Дурдсан хандлагууд нь өөр өөрийн давуу болон хязгаарлагдмал талтай юм. Тэдгээр нь бүхэлдээ тоталитаризм хэмээх олон талтай нарийн нийлмэл үзэгдэлийг аль болохуйц тал бүрээс нь судлаж бүхэл дүр зураг, агуулгыг нь гаргаж илэрхийлэхэд тус дөхөм болдог байна. Гэхдээ тэдгээр хандлагууд тоталитаризмын судалгааны онолын бие даасан үндэслэл, чиглэл болж хараахан чадаагүй, тэгэх эмпирик баримт материалын хэмжээ, бааз ч хүрэлцээтэй биш ажээ.

Эл өгүүлэлд тусгайлан авч үзвэл зохих дараагийн асуулт бол тоталитаризмын судалгаанд эрдэмтэдээс баримталсан арга зүйн тухай асуулт юм. Эрдэмтэдийн баримталсан арга зүй, дэвшүүлэн тавьсан үзэл санал нь олон янз, хэмжээ дамжаа нь ч нэлээд байна. Гэхдээ үүнийг тэдгээр арга зүйн хандлагууд тоогоороо олон гэж ойлгож болохгүй. Арга зүй олон байгаа биш, харин ямар нэг арга зүйн тавил, хандлагыг шаардсан, мөн тэр дагуу авч үзэж хариу тайлбар өгвөл зохих тодорхой асуултууд олон байна.

Эрдэмтдээс баримталсан арга зүйн хандлагууд нь голдуу аль нэг маргаантай, эсвэл шинээр тавигдаж буй тодорхой асуудлыг авч үзэх явцад гарч ирж тавигдсан байна. Тиймээс тэдгээрийг хэд хэдэн бүлэг асуулт болгож эмхлэн цэгцлэх, бас авч үзэх логик дарааллыг нь анхаарч бодох хэрэгтэй юм.

Тоталитаризмын судалгаанд арга зүйн ямар нэг баримтлал шаардсан, маргаантай, нарийн ээдрээтэй асуултын бүрэн жагсаалтыг гаргаж тоочих аргагүй, харин тэдгээрийг хоорондын нь уялдаа холбоо, ойролцоо, төрөл байдлаар нь хураан зангидаж авч үзэх боломжтой. Тэдгээр нь: 1. тоталитаризмын эх үүсвэр (генезис), үүсэн гарахад нь нөлөөлсөн түүхэн нөхцөл байдал, цаг үе, субъектив хүчин зүйлс; тоталитаризм бодит дэглэм болж бүрэлдэн тогтсон үйл явц, үе шат; тоталитаризмын мөн чанар, үндсэн шинж, илэрэл, зохион байгуулалт, түүний бүтэц, бүрдэл хэсэг; тоталитаризмын түүхэн хэв маяг, хэлбэр, тэдгээрийн нийтлэг тал ба ялгаа онцлог; тоталитаризм бодитойгоор оршин байгаа эсэхийг тогтоох шалгуур, үзүүлэлт; тоталитаризм ба улс төрийн бусад дарангуй дэглэмүүдийн харьцаа; тоталитаризмын сулрал, нуралт, түүхэн сургамж, түүний сэргэлт, гарч ирэх боломж, аюулыг сэрэмжлэх асуудал; 2. тоталитаризмын эдгээр болон бусад асуудал, тодорхой асуултуудыг судлан шинжлэхдээ ямар арга зүй, судалгааны аргаар хэрхэн яаж хандах вэ; тухайлбал, тоталитаризмын онол, үзэл баримтлалуудад яаж хандах вэ; “тоталитаризм” гэсэн ойлголт ер нь ямар хүрээ багтаамж, агуулгатай вэ, түүнд шинжлэх ухааны танин мэдэхүйн үүрэг, ач холбогдол бий эсэх, түүнийг яаж тогтоох вэ; тоталитаризмын судалгаанд түүний онолын зэрэгцээ нийгэм-хүмүүнлэгийн бусад салбар ухаануудын оролцоог яаж зүй зохистой хангах вэ, тоталитаризмын судалгааны цаашдын асуудал, тэр талаар гарч буй маргаан зэрэг асуултуудыг дурдаж болно.

Эдгээр асуудал, тодорхой асуултууд эдүгээ нэг талаар зохих түвшинд судлагдаж онол, арга зүйн тодорхой ойлголт, дүгнэлт бий болсон, голж чамлахааргүй мэдлэгийн сан бүрэлдэж өнөөгийн эрдэм шинжилгээний ажил

болон сургалт боловсролын хэрэглээний эргэлтэд нэгэнт орж үр дүнгээ өгч байгаа билээ. Нөгөөтэйгүүр тэдгээр асуудал, асуултуудыг цааш шат ахиулж гүнзгийрүүлэн судлах, ялангуяа одоо ч нэг мөр болж шийдвэрлэгдээгүй, маргаантай байгаа асуултуудыг бодож боловсруулсан арга зүйн дагуу сайтар судлах шаардлага чухлаар тавигдсан хэвээр байна.

Одоо тэдгээрийн зарим гол, нийтлэг агуулгыг хөндөж авч үзье. Тоталитаризмын түүхэн гарал үүсэл, эх үндэсийн тухай асуулт зарим талаар одоо ч маргаантай байна. Зарим эрдэмтэн түүнийг өмнөх XVII-XIX зуун, заримдаа бүр эртний үе болон дундад зууны гүнээс эрж хайж “олж” байгаа бол зарим эрдэмтэн түүний эсрэгээр тэдгээрийг зөвхөн XX зууны 20, 30–аад оны хүрээгээр зааглан хязгаарлаж авч үзсэн, түүнчлэн тодорхой улс оронд тоталитар дэглэм тогтсоныг тэр орны үндэстэн, ард түмний нийгэм, улс төрийн амьдралын түүхэн уламжлал, нийгэм-сэтгэл зүй, ухамсарын өвөрмөц онцлогтой холбосон, эсвэл Муссолини, Гитлер, Сталин, тэдний ойрын тойрон хүрээлэгчдийн бодлого, зорилго, үзэл санаатай холбон тайлбарлаж байгаа зэрэг нь өрөөсгөл, учир дутагдалтай үзэл, хандлага болохыг судлагч эрдэмтэдийн олонхи нь шүүмжлэн авч үзэж тэдгээрийн арга зүйн үндэсийг гаргаж тавьсан байна. Тухайлбал өнөөгийн судлагч эрдэмтэдийн нэлээд нь, тэр дотор жишээлбэл А.П.Бутенко тийм өрөөсгөл дүгнэлт, үзэл бодлыг К.Поппер зохиолдоо гаргаж тавьсан, тодруулж хэлбэл тэрбээр тоталитаризмын эх сурвалж, ялангуяа үзэл санааны үндэс нь Платон, наашлуулбал Гегель, Маркс нарын сургаалд агуулагдсан гэж үзсэн нь алдаатай бөгөөд тэр алдаанд хүргэсэн онол, арга зүйн алдаа бол тоталитаризмын аль нэг үзэл санаа, шинжийг бусдаас нь хийсвэрлэн салгаж аваад түүнийг түүхийн өмнөх үеүдээс “эрж олсон”, эргүүлээд түүгээр тоталитаризмыг бүхэлд нь төлөөлүүлэн тайлбарлаж, эл дэглэм эртний үзэгдэл мэтээр үзсэнд оршино гэсэн арга зүйн ач холбогдолтой шүүмжлэлт санал хэлжээ²⁵.

К.Попперийн үзэлтэй ойролцоо санал бодолыг Л.Шапиро зэрэг бусад зарим эрдэмтэн мөн адил гаргаж байсныг оросын эрдэмтэн Ю.И.Игрицкий шүүмжилсэн байна²⁶. Ер нь тоталитаризм хэмээх бүхэл үзэгдэлийг түүний бүрдэл хэсгүүдийн аль нэгээр нь механик байдлаар, хийсвэрлэн төлөөлүүлж ойлгох өрөөсгөл, алдаатай ойлголт нь тоталитаризм ба авторитаризм, бусад хэлбэрийн дарангуй дэглэмүүдийг хооронд нь хутгах, адилтган үзэх, түүнчлэн тоталитаризмын аль нэг, эсвэл хэсэг шинж чанар ямар нэг орны улс төрийн амьдралд байгааг олж тогтоогоод түүнийг үндэс болгож тухайн оронд бүхэлдээ тоталитар дэглэм тогтож байна гэх зэргээр үзэх алдаанд мөн адил хүргэдэгийг бусад зарим эрдэмтний бүтээлээс ч жишээ татан дурдаж болно. Тиймээс А.П.Бутенко нэлээд тохиолддог энэ өрөөсгөл хандлага, алдаанд онол, арга зүйн дүгнэлт хийж тоталитаризмын шинж, бүрдэл хэсгүүд нь хоорондоо салшгүй холбоотой, бүхэл, цогцолбор чанартай бөгөөд түүнийг тоталитаризмын үүсэл,

²⁵ А.П.Бутенко. Социологические вопросы истории и теории тоталитаризма. -Социологические исследования. -1998, №6.

²⁶ Ю.И. Игрицкий. Концепция тоталитаризма: уроки многолетних дискуссий на Западе. -История СССР (Научный журнал АН СССР). 1990.№6, с. 172-190.

тогтнол, бусад дэглэмээс ялгагдах ялгааны асуудлыг судлахдаа чухалчлан анхаарах хэрэгтэйг заажээ²⁷.

Тоталитаризмын судалгааны арга зүйн чухал асуудлын нэг бол тоталитаризмын онол, “тоталитаризм” хэмээх ойлголтод яаж хандах вэ гэсэн асуулттай холбогдон гарч буй хандлага, үзэл бодолын тухай юм. Өнөөгийн судлагчид тоталитаризмын онолд хандахдаа: нэгдүгээрт, түүнийг баримтлаж судалгаандаа бүтээлчээр, уян хатан хэрэглэх, хоёрдугаарт үгүйсгэх, гуравдугаарт эргэлзэх байр суурь бүхий үндсэндээ гурван янзын хандлагатай байгааг оросын эрдэмтэд тэмдэглэжээ²⁸. Тэдгээр тус бүрийн цаана нь тухайн эрдэмтний байр суурь, үзэл баримтлал оршиж нөлөөлдөг нь мэдээж боловч хамгийн гол нь тэрхүү байр суурь, үзэл бодол нь бодож боловсруулсан үндэслэл, судалгаанд тулгуурласан байх нь чухал ажээ. Тоталитаризмын онол, ойлголтод хандахдаа тэдгээрийн ололт амжилт, давуу тал, эсвэл сул тал, дутагдалын аль нэгийг иш үндэс болгож тэр дагуу туйлшрах, өрөөсгөл байдал гаргах явдал гардаг байна.

Тоталитаризмын онолыг баримтлахдаа эл онол цэгцрэн боловсрогдсон учираас судалгааг хөтлөн авч явж үр дүнд хүргэнэ, тоталитаризмын олон талтай, янз бүрийн асуудлын алийг нь ч судлахад түгээмэл байдлаар нийцэж тохирно гэх мэтээр бүдүүн тойм, мухраар хандаж болохгүйтэй нэгэн адил эл онолын аль нэг дутагдал, сул талыг иш үндэс болгож түүнийг бүхэлд нь үгүйсгэж болохгүй гэсэн арга зүйн сануулга тоталитаризмын судалгааны туршлагаас урган гарсан зүйл юм. Тухайлбал 1970-аад онд өрнөдөд тоталитаризмын онолыг шүүмжилж түүнийг хэрэгсэхгүй болгох нь судалгаанд нэг их сүрхий гарз хохирол болохгүй, ер нь түүний танин мэдэхүйн боломж нь хомс болсон гэх мэтээр үзэхдээ эл онол 1950-иад онд бололвсрогдох явцад зарим дутагдал, хязгаарлагдмал талыг агуулж байсан хэсэг бусад сул талыг нь иш үндэс болгож өрөөсгөл хандсан явдал бол арга зүйн чанартай туйлшрал байсан нь эдүгээ тодорхой болсон зүйл билээ.

Тоталитаризм ХХ зуунд дэлхийн арав орчим оронд тогтон ноёрхсон асуудлыг түүхийн ухааны аспект ба онолын судалгааг хослуулан амжилттай судлаж томоохон, суурь бүтээл туурвисан профессор Я.С.Драбкины судалгааны багийнхан уг асуудлыг авч үзэхдээ тоталитаризмын онол, ойлголтод эхлээд зориуд эргэлзээтэй хандаж, бэлтгэл судалгаа хийсний үндсэн дээр эл онол, ойлголт нь шинжлэх ухааны танин мэдэхүйн үүрэг, ач холбогдолтой болохыг тогтоож байж том хэмжээтэй судалгааг эхэлсэн талаар уг бүтээлийн оршилд бичсэн нь²⁹ жирийн нэг тайлбар, таталбар биш, харин шинжлэх ухааны арга зүйн утга учиртай санаа юм.

Өрнөдийн нэлээд эрдэмтэн “тоталитаризм” гэсэн ойлголтыг шинжлэх ухаанч зарчмаар нягт нямбай, тодорхой хандаж хэрэглэх ёстой бөгөөд энэ нь онол, арга зүйн чухал ач холбогдолтой болохыг сануулсаар иржээ. Ийм

²⁷ А.П.Бутенко. Социологические вопросы истории и теории тоталитаризма. -Социологические исследования. -1998, №6.

²⁸ Тоталитаризм в Европе XX века. Из истории идеологий, режимов и их преодоления. Руководители авторского коллектива Я.С. Драбкин, Н.П.Комолова. М., 1996, с. 7

²⁹ Мөн зохиол.с. 7

сануулгыг Х.Арендт анх гаргаж “Тоталитаризмын эх үүсвэр” зохиолын 1966 оны хэвлэлд зориулж бичсэн удиртгалдаа тэмдэглэсэн байна³⁰.

Энэ талаар өнөөгийн ном зохиолд тоталитаризмын ойлголтын агуулга, хамрах хүрээг үндэслэлтэй тогтоож тодорхойлох, түүнийг нэг бол хэт өргөсгөж хүн төрөлхтөний түүхэнд байсан дарангуй дэглэмүүдийг илэрхийлдэг өргөн багтаамжтай ойлголт мэтээр үзэж хандах, эсвэл хэт явцууруулж Итали, Герман, ЗХУ-д түүхийн тодорхой нэг зурвас үед түр зуур тогтож байсан дэглэмийг л тэмдэглэсэн ойлголт мэтээр үзэх явдлын аль нь ч өрөөсгөл, алдаатай бөгөөд түүхэн үнэн, бодит байдалд нийцэхгүй гэсэн арга зүйн үзэл санааг эрдэмтэд илэрхийлж байгаа юм.

Дээр өгүүлсэн зүйл бол тоталитаризмын судалгаанд эрдэмтэдээс баримталсан арга зүйн хандлагуудын зарим нийтлэг талыг тоймлож товч дурдсан хэрэг юм. Энэ явцад тоталитаризмын судалгаанд жинтэй хувь нэмэр оруулсан томоохон эрдэмтэдийн арга зүйн баримтлал, үзэл санаа бүрхэг үлдэж байна. Тиймээс тэдгээрийн заримыг хөндөж үзэх хэрэгтэй.

Тоталитаризмын асуудлаар гарсан анхны суурь бөгөөд одоо ч ач холбогдолтой, чухал хэвээр байгаа бүтээл бол Ф.А.Хаекын “Боолчлогдох зам” зохиол билээ. Зохиолын гол үзэл санаа, дүгнэлтүүдийг тусгайлж авч үзэх хэрэгтэй бөгөөд бид энд түүний арга зүйн баримтлалын утгыг товч илэрхийлэхийг оролдов.

Ф.Хаек зохиолдоо Германд национал-социалист номлолыг удирдлага болгосон нацист тоталитар дэглэм тогтсон нь зөвхөн энэ орон төдийгүй нийт Европ, дэлхийд учирч буй аюул бөгөөд түүнийг нэн түрүүнд бодитойгоор шинжлэн судлаж, үүсэн гарсан үндэс суурь, жинхэнэ шалтгааныг нь илэрүүлэн гаргах хэрэгтэй гэсэн шинжлэх ухаанч зорилго бүхий арга зүйгээр ханджээ. Ф.Хаек түүний дагуу асуудлыг шинжлэхдээ нацизмын уг чанар, гарал үүслийн жинхэнэ, бодит үндэс шалтгааныг “сүүлийн үед германчуудыг ерөөс дотоод мөн чанараараа нүгэл хилэнцээр дүүрсэн үндэстэн гэсэн үг яриа нэлээд их сонсдох болсны” дагуу герман үндэстний ухамсар, сэтгэл зүйн онцлогоос эрж хайх биш, “харин сүүлийн далан жилийн дотор чухам ямар нөхцөл байдлын улмаас германы нийгэмд тодорхой үзэл санаа хүч авч, зонхилох үзэл санаа болоо вэ, үүний улмаас яагаад Германд тодорхой хүрээний хүмүүс засгийн эрхэнд ороо вэ гэдэгт асуудлын учир байгаа юм” гэж хандах ёстой гэсэн үзэл санааг арга зүйн гол баримтлал болгосон байна³¹. Ф.Хаек тэр дагуу Германд фашизм, нацизм үүссэн үндэс шалтгааныг нийгмийн амьдралын бодит харилцаа, үйл явцын зонхилох хандлагаас эрж хайж тэр нь социалист хандлага юм гэсэн хариу олж түүнийгээ “фашизм, нацизм хөгжин мандсан нь өмнөх үеийн социалист хандлагын хариу байсан юм биш, тэр хандлагын зайлашгүй үргэлжлэл, хөгжил байсан” гэж томъёолон бичжээ³².

³⁰ Х.Арендт. Истоки тоталитаризма. Перевод с английского. М., ЦентрКом, 1996, с. 13

³¹ Ф.А. Хаек. Боолчлогдох зам. Орос хэлнээс орчуулсан П.Чойжил. УБ., Монсудар, 2005, 14-15 дахь талд

³² Мөн зохиол. 11 дэх талд

Хаек зохиолдоо цааш нь социализм яагаад боолчлол буюу тоталитаризмд хөтлөн аваачих зам болдог вэ гэдгийг дэлгэрэнгүй, гол асуудал болгож авч үзсэн бөгөөд тэр нь бидний энд өгүүлэх зүйл биш юм. Түүний оронд Ф.Хаек тоталитаризм үүсэн тогтох үндэс шалтгаан бол нийгмийн амьдралын материаллаг үндэс суурь болох эдийн засаг, түүнийг социализмын зарчмаар төлөвлөж төвлөрүүлэн удирдсан, хянасан явдалд оршино гэж дүгнэн үзсэн нь асуудалд эдийн засгийн талаас хандсан, тоталитаризмын эдийн засгийн үндсийг гаргаж тавьсан хэрэг юм гэдгийг тэмдэглэвэл зохино. Энэ нь тоталитаризмын судалгаанд оруулсан түүний том хувь нэмэр бөгөөд түүнд нь тэрбээр тухайн үед хэдийнээ томоохон эдийн засагч эрдэмтэн болж нэгэнт тодроод байсан явдал ихээхэн нөлөөлсөн ажээ.

Тоталитаризмыг судалсан томоохон эрдэмтэдээс К.Попперийн баримталсан онол, арга зүйн хандлага өвөрмөц онцлогтой билээ. Энд түүнийг хэн хүн өөрийн ойлгосноор тайлбарлах хэрэггүй, учир нь тэрбээр тэрхүү арга зүйгээ зохиолынхоо оршилд өөрөө тов тодорхой илэрхийлснийг иш татах нь зөв юм. К.Поппер: "... уг номонд нээлттэй нийгмийн асуудалд шинжлэх ухааны шүүмжлэлт болон рационал аргыг хэрэглэх боломжийг судлах оролдлого хийсэн юм. Мөн нийгмийг ардчилсан ёсоор өөрчлөн байгуулах зарчмуудыг задлан шинжлэв; зарчмын тухайд би "нийгмийн үл гүйцэлдэх (Utopian) инженерчлэл"-ийг сөргүүлж "нийгмийн шатлалт (piecemeal) инженерчлэл (ялгааг IX бүлэгт тайлбарлав)" гэсэн томъёолол гаргав. Түүнчлэн нийгмийг өөрчлөн байгуулах зүй зохистой хандах зам дээр буй зарим саад тогторыг арилгахыг оролдсон болно. Үүнийгээ ардчилсан өөрчлөлтийг хэрэгжүүлэх боломжийн эсрэг атгаг үнэмшлийг их газар авахуулсны хариуцлагыг хүлээх ёстой нийгмийн философийн сургаалыг шүүмжлэх замаар хийлээ. Эдгээр философиос хамгийн их нөлөө бүхий нэг сургаалыг нь би түүхчлэхгүй (historicism) хэмээн нэрийдэв. Түүхчлэхүйн зарим чухал хэлбэрийн үүсч дэлгэрсэн, нөлөө нь тархсан түүх бол энэ номонд авч үзсэн үндсэн сэдвийн нэг бөгөөд тийм ч учраас түүнийг бүр тэрхүү түүхчлэгч философийн хөгжлийн тухай судрын хуудасны зах дээр тэмдэглэсэн тайлбар ч гэж тодорхойлж болно.

...Хэдийгээр би физикийн аргачлалыг голчлон сонирхож байгаа ч... зарим нийгмийн шинжлэх ухаан, ялангуяа нийгмийн философийн олон талаар хангалтгүй буй байдал миний сонирхолыг олон жилийн турш татаж ирсэн юм. Тэгэхлээр, мэдээж, тэдгээрийн арга зүйн асуудал гарч ирж таарна. Энэ чиглэлийн миний сонирхол болвоос тоталитаризм үүссэн болон төрөл бүрийн нийгмийн шинжлэх ухаан, нийгмийн философийн сургаал түүнийг ухаж ойлгох чадваргүй байснаас үүдэн улам гүнзгийрсэн билээ.

Үүнтэй уялдан би нэг асуултыг бүр онцгой чухал гэж үзсэн юм. Тоталитаризмын аль нэг хэлбэр зайлшгүй байх ёстой гэсэн санааг олонтоо сонсож болно. Ухаантай хийгээд боловсрол мэдлэгтэйнхээ хувьд юу хэлснийхээ хариуцлагыг бүрэн хүлээх ёстой хүмүүсээс маш олон нь тоталитаризмаас зайлах арга байхгүй гэж зүтгэдэг. ... Тэд нар, хамтын төлөвлөлтийн аргачлалыг хэрэглэхгүйгээр манай аж үйлдвэрийн тогтолцоо цаашид хэвийн ажиллаж чадахгүй гэж нотлоод, ийнхүү хамтын эдийн засгийн

тогтолцоо зайлшгүй юм чинь нийгмийн амьдралыг тоталитар зарчмаар зохион байгуулахаас өөр зам байхгүй гэсэн дүгнэлт хийцгээдэг.

Иймэрхүү үндэслэлүүд боломжийн үнэмшилтэй сонсогдох нь бий. Гэтэл эдгээр асуудлын хувьд, зөвхөн үнэмшилтэй байна гэдэг нь чигийг заах луужин болж чадахгүй. Чухамдаа бол дараах аргазүйн асуултад өөртөө хариулт өгөхгүйгээр эдгээр тусгай асуултыг хэлэлцэж эхлэхийн ч хэрэг байхгүй: аль нэгэн нийгмийн шинжлэх ухаан тийм төгс төгөлдөр түүхэн мэргэ тавьж чадах уу ?

Энэ бол яг нийгмийн шинжлэх ухааны арга зүйн асуудал. Энэ нь аль нэгэн түүхэн таамаглалыг дэмжсэн аливаа тухайлсан үндэслэлийг ямар ч байдлаар шүүмжлэхээс илүү суурилаг шинжтэй юм.

Би уг асуудлыг тун хянуур судласны үр дүнд тиймэрхүү төгс төгөлдөр түүхэн мэргэ нь шинжлэх ухааны аргатай өчүүхэн ч хавирах зүйлгүй гэдэгт бат итгэсэн юм.

...Шудрага ёсны тухай Платоны онол, орчин үеийн тоталитаризмын онол практиктэй төстэйг олж мэдэн сэрдхийж баймааж нь эл номонд хөндсөн асуудлуудыг авч үзэх явдал хичнээн чухлыг сая ойлгож болох юм шиг санагдана” гэж бичжээ³³.

К.Попперын зохиолын онолын үзэл санаа, утга агуулга хийгээд арга зүйн баримтлалыг ойлгоход түүний бичсэн бас нэг товч тайлбар багагүй ач холбогдолтой болно. Тэрбээр зохиол нь 1992 онд орос хэлээр нийтлэгдэхэд оросын уншигчдад хандаж бичсэн захидалдаа: “Би бээр энэхүү номондоо гитлеризм үүсэн гарахад хүргэсэн түүхийг мөшгин судлахаар шийдвэрлэсэн бөгөөд түүний дагуу ангиудыг нэр томъёогоор сэтгэн ойлгосон, бас бөөнөөр хорих лагериудыг бодож санаачилсан анхны улс төрийн үзэл сурталч болох агуу их гүн ухаантан Платоны сургаалд хандсан билээ. Харин Сталины бие хүн нь надад Карл Марксын гүн ухааныг судлах сэдэл төрүүлсэн юм. Би марксизмыг шүүмжлэнгээ ямар нэг хэмжээгээр өөрийгөө ч шүүмжилсэн, учир нь би идэр залуудаа марксистаар барахгүй коммунист байсан юм” гэж бичжээ³⁴. (“Нээлттэй нийгэм, түүний дайснууд”-ыг Ц.Гомбосүрэн абугай англи хэвлэлээс нь монголчилсан тул К.Попперийн эл захидал түүнд орж орчуулагдаагүй байна).

К.Поппер тийнхүү “хаалттай нийгэм” болох тоталитаризмыг өөрийн боловсруулсан шинжлэх ухааны шүүмжлэлт рационал аргаар судлаж түүний үзэл санааны эх сурвалжийг илрүүлэн гаргах зорилготой арга зүйн хандлагыг баримталсан байна.

Х.Арендтын “Тоталитаризмын эх үүсвэр” зохиол нь тухай үедээ судалгааны онол, арга зүйн өндөр түвшинд бичигдсэн, тиймээс ч тоталитаризмыг цаашдаа өөрийн нь мөн чанарт нийцсэн аспектээр судлах онол, арга зүйн үндсийг тавьсан суурь бүтээл болсон гэж нэлээд эрдэмтэн өндөр

³³ Карл Р.Поппер. Нээлттэй нийгэм, түүний дайснууд. I боть. Платоны увдис. Англи хэлнээс орчуулсан Ц.Гомбосүрэн. УБ., Монсудар, 2006, 10-14 дэх талд.

³⁴ К.Поппер. Письмо моим русским читателям (1992). –Карл Поппер. Открытое общество и его враги. Том I. Чары Платона. Перевод с англ. Под ред. В.Н.Садовского.- М.,Феникс, 1992, с.7

үнэлсэн байдаг³⁵. Эл зохиолын онолын үзэл санааны талаар энд авч үзэх боломжгүй бөгөөд харин арга зүйн баримтлал, хандлагыг нь тусгайлан өгүүлэх шаардлага уг нь байгаа юм. Гэвч тэр нь олон талтай, нарийн асуудал тул санаснаар товчилж тоймлоно гэвэл утга агуулга нь бүрхэг үлдэхэд хүрнэ. Тиймээс түүний арга зүйн баримтлалын зорилго, гол зарчмыг нь дараах өгүүлбэрээр товч дурдаж байна.

Х.Арендт зохиолдоо тоталитаризм үүсэн тогтсон түүхэн үйл явц, түүний үзэл санаа, нийгэм, улс төрийн үндэс, эл дэглэмийн мөн чанар, шинжүүдийг судлан шинжилсэн бөгөөд түүндээ түүхийн аспект ба судлагдахуунд асуудлын үүднээс хандахыг (проблемный подход) арга зүйн зарчим, удирдамж болгож хэрэглэсэн байна. Үүний үр дүнд эл зохиол тоталитаризм үүсэн тогтсоныг түүхийн үүднээс судлан шинжилсэн, онолын түвшинд нэгтгэн дүгнэсэн түүх-улс төрийн философийн бүтээл болжээ.

Хуучны ЗХУ болон Зүүн ба Төв Европын социалист орнуудад 1960-аад он, зарим талаар 1950-иад оноос диссидент буюу өөрөөр бодож сэтгэгчдийн хөдөлгөөн бий болж тэдний дуу хоолой коммунист дэглэмийг шүүмжилсэн өгүүлэл, захидал, ухуулах бичиг, бие даасан ном зохиол, товхимол зэрэг хэлбэрээр, “өөрийн хэвлэл” гэж нэрлэсэн албан ёсны бус хэвлэлээр дамжин нийтэд хүрч байсан билээ. Диссидентүүдийн дотроос оросын академич А.Д.Сахаров “Размышления о прогрессе, мирном сосуществовании и интеллектуальной свободе” (1968), философич эрдэмтэн профессор А.А.Зиновьев “Зияющие высоты”, “Светлое будущее”(1976, 1979), югославын нам төрийн зүтгэлтэн байсан, нийтлэлч, эрдэмтэн М.Жилас “New Class: An Analysis of the Communist System” (Шина анги. Коммунист системд хийсэн шинжилгээ-1957), “Conversations with Stalin” (Сталинтай хийсэн ярилцлага.-1962), “The Unperfect Society” (Төгс бус нийгэм.-1966), болгарын философч эрдэмтэн Желю Желев “Фашизмът. Тоталитарната държава” (Фашизм. Тоталитар төр.-1967) нар бие даасан товхимол, ном зохиол бичсэнийг голцуу өрнөдийн орнуудад орчуулан нийтэлсэн байна. Эдгээр эрдэмтэд зохиол бүтээлдээ өөрсдийн аж төрж байсан эх орон дахь коммунист дэглэмийг хурцаар шүүмжилж байв.

Дурдсан бүтээлүүдийн дотроос жишээ болгож Ж.Желевийн зохиолын онол, арга зүйн баримтлалын талаар товч өгүүлэе. Энэ нь тус зохиол тоталитаризмыг Герман, зарим талаар Италийн фашист дэглэм бүхий төрийн жишээнд тулгуурлаж авч үзсэн, цаад далд утга санаагаараа социалист орнууд дахь коммунист дэглэмүүдийн дүр зургийг давхар зурагласан, эрдэм шинжилгээний шинжтэй, бас эл сэдвээр социалист орнуудад анх шахуу бичигдсэн зохиол учираас сонирхолтой байгаа юм. Үүнд бас нэг зүйлийг нэмж хэлэхэд Ж.Желев хэдийгээр коммунист дэглэмд таагүй ханддаг, өөрөөр бодож сэтгэдэг байсан ч гэсэн зохиолоо бүхэлдээ марксист онолын үүднээс бичжээ. Тиймээс түүний

³⁵ От редакторов русского издания.-Х. Арендт. Истоки тоталитаризма. Перевод с английского. М., ЦентрКом, 1996, с. 5

баримталсан арга зүй тоталитаризмын асуудлаар гарсан бусад олон зохиолуудын арга зүйн баримтлалуудаас нэлээд өөр, онцлогтой юм.

Ж.Желев фашист тоталитаризмыг судлахад марксизмын нийгмийн тухай онол болох түүхийн материализм нь онол, арга зүйн үндэс болно гэж үзжээ. Түүний үзлээр түүхийн материализмын арга зүйн үүрэг, ач холбогдол нь ялангуяа тоталитаризмын эдийн засгийн үндэс суурь ба улс төрийн давхаргын холбоо хамаарал, харилцан нөлөөллийг судлан гаргах давуу боломж олгодогт орших ажээ³⁶. Ж.Желев тэр дагуу фашизм, Германы тоталитар төрийг авч үзэхэд дурдсан арга зүй үнэндээ ч “ажиллаж” зохих үр дүнгээ өгсөн байна. Тэрбээр тухайлбал эл арга зүйн үүднээс Германы тоталитар төр нь улс орны эдийн засгийг гартаа төвлөрүүлэн удирдаж богино хугацаанд хямралаас гаргасан, түүний үр дүнд цааш өсч хөгжих болсон эдийн засаг нь эргээд тоталитар төрийн хүч чадлын үндэс суурь болсон, Германд ажилгүйдэл арилж олон нийт нацизмыг дэмжих болсон зэрэг үзэгдэл, үйл явцыг гарган тавьжээ.

Дурдсан зүйлийн зэрэгцээ Ж.Желев түүхийн материализмын арга зүй нь бусад орнуудад тогтсон тоталитар, фашист дэглэмүүдийг судлаж хооронд нь харьцуулах, нэгтгэн дүгнэх замаар фашист тоталитар төрийн онолын санаалаг ерөнхий загварыг гаргах бололцоо олгоно гэсэн байна³⁷. Эл зохиол бүхэлдээ тэр дагуу бичигдсэн байгаа бөгөөд тоталитар төрийн мөн чанар, шинж, зохион байгуулалт, бүтэц, үйл ажиллагааг зохих түвшинд дэлгэрэнгүй гаргаж илэрхийлсэн сонирхолтой бүтээл болсныг тэмдэглэх хэрэгтэй.

Оросын эрдэмтэдээс 1990-ээд оноос хойш туурвисан эрдэм шинжилгээний бие даасан ном зохиолуудын дотроос одоогоор хамгийн жинтэй, чухал нь профессор Я.С.Драбкин, Н.П.Комолова нарын удирдлагаар бэлтгэгдэж 1996 онд нийтлэгдсэн “Тоталитаризм в Европе XX века. Из истории идеологий, режимов и их преодоления” (“XX зууны Европ дахь тоталитаризм. Үзэл суртал, дэглэмүүд ба тэдгээрийг даван туулсан түүхээс”) гэсэн нэгэн сэдэвт хамтын бүтээл юм. Энэ бол том форматаар хэвлэгдсэн 45 хэвлэлийн хуудас бүхий хэмжээгээрээ ч, авч үзсэн асуудлын хүрээ багтаамжаараа том, суурь бүтээл бөгөөд эрдэмтэд түүндээ тоталитар дэглэм ЗХУ, Итали, Германд, мөн зарим талаар Европын социалист орнууд болон Испани, Португал, Грект тогтсон асуудал, түүнчлэн тоталитаризмыг эсэргүүцсэн хөдөлгөөн, тоталитар дэглэмүүд нурсан үйл явцыг судлан шинжилсэн байна. Эл бүтээлийн онол, арга зүйн баримтлал нь тоталитаризмд түүхийн ухааны үүднээс, бас асуудалд сэдэвчилж хандах, онолын түвшинд нэгтгэн дүгнэх зарчимд үндэслэсэн, түүгээрээ Х.Арендтын зохиолынхтой нэлээд төсөөтэй, ойролцоо бөгөөд гэхдээ тоталитаризмын судалгааны сүүлийн үеийн ололт амжилтад түшиглэсэн шинэлэг, өндөр түвшинд боловсрогдсоныг А.П.Бутенко, Ю.И.Игрицкий, А.О.Чубарьян нар сайшаан үнэлж тэмдэглэжээ.

³⁶ Ж. Желев. Фашизм. Тоталитарное государство. Перевод с болгарского. М., Новости, 1991, с. 28

³⁷ Мөн зохиол. с. 44-45

Бид эл өгүүлэлд тоталитаризмын судалгаанд эрдэмтэдээс баримталсан онол, арга зүйн нийтлэг болон зарим ялгаатай талыг тоймлон авч үзлээ. Тэдгээр нь авч үзсэн асуудлын шинж чанар, агуулга, онцлог, судалгааны аспект хийгээд судлагч эрдэмтэдийн үзэл, үнэмшил, улс төр, үзэл суртлын чиг баримжаа, туршлага зэрэг хүчин зүйлстэй ямар нэг хэмжээгээр холбоотой байгаа нь ажиглагдаж байна. Эрдэмтэдийн баримталсан онол, арга зүйн тэдгээр хандлага, үндэслэлүүд нь бүхэлдээ, эцсийн дүндээ “тоталитаризм” хэмээх нарийн нийлмэл түүхэн үзэгдэлийг олон талаас нь судлан шинжлэж, түүний бүхэл, ерөнхий дүр төрх, шинж чанарыг онолын нэгтгэн дүгнэсэн санаалаг загвараар гаргаж томъёолоход чиглэгдэж, түүнд өөр өөрийн зохих хувь нэмрээ оруулсан байна гэж дүгнэн хэлж болно.

Abstract

The purpose set by the author of the article is to review theory and methodology used by western scholars to study totalitarianism. The problem of the totalitarianism is difficult. Scholars from the different countries had a different views about the totalitarianism. Also they have a diverse theory and methodology. We can classify them like this: political, constitutional law, political systems theory, modernizational, social and political psychology, socio-cultural and political anthropology. They all have advantages and weaknesses but they restore one another, allowing us to learn more about totalitarianism.